Баян-Олгий аймгийн еронхий боловсролын сургуулиуд шинэ хичээлийн жилийн нээлтээ хийв.

Еронхий боловсролын сургуульд 22 100 орчим хvvхэд, цэцэрлэгvvдэд 11 100 хvvхэд суралцах юм. 12 жилийн анхны сурагчид энэ хичээлийн жилд тогсолтоо хийх юм байна. Боловсролын салбарт энэ онд улсын тосвоос 6,4 тэрбум тогрогийн хоронго оруулалт хийсэн нь онгорсон оныхоос 2,4 тэрбумаар илvv байна. Хичээлийн жилтэй холбогдуулан сургуулиудын засвар, шинэтгэл, сургалтын тоног тохооромжоор хангах ажил амжилттай хэрэгжиж омнох зорилттой холбогдуулан багш сурган хvмvvжvvлэгчид болон сургуулийн захирал, цэцэрлэгийн эрхлэгч нарын хурал зовлолгоонийг тус тус чанартай хийхэд аймгийн ИТХТ, ЗДТГ, боловсролын байгууллагууд онцгой анхаарсан байна. Багш нарын сахилга хариуцлагыг ондоржvvлэх vvднээс ёс зvйн аймгийн зовлол долоон хvний бvрэлдэхvvнтэй байгуулагдав. Боловсролын салбар энэ оноос сургалтын орчин, сурлагын чанарыг ахиулах, хvvхэд бvрийн авъяасыг нээх, казах сурагчдын торийн албаны хэлний мэдлэгийг дээшлvvлэх, анги бvлэг бvрийг номын сантай болгож, сургуулиудын номын сангуудыг тохижуулах, сурагчдыг дvрэмт хувцасаар хангахад ахиц гаргах зэрэг зорилтуудыг дэвшvvлсэн байна.